




МОНГОЛ УЛСЫН ИХ СУРГУУЛЬ

МУИС-ийн ОЮУТАН МОНГОЛЫН ИРЭЭДҮЙ

NATIONAL UNIVERSITY OF MONGOLIA



ADMISSION - 2016

ЭЛСЭЛТ 2016

МЭРГЭЖЛЭЭ
СУРГУУЛИА

| ЗӨВ СОНГОЁ

МУИС-ийн ТАНИЛЦУУЛГА

Монгол улсын анхны их сургууль МУИС нь 1942 онд байгуулагдсан үеэсээ боловсрол, шинжлэх ухаан, соёлын төв, ард түмнийг соён гэгээрүүлж, хөгжил өөд хөтлөгч болж ирсэн юм. Энэ үүргээ одоо ч амжилттай биелүүлж дэлхий хэмжээний их сургууль болохоор зорьж байна.

МУИС нь байгаль, нийгэм, хүмүүнлэгийн ухаан, инженерчлэл, хууль, бизнесийн удирдлага, олон улсын харилцаа, нийтийн удирдлагын бакалавр, магистр, докторын сургалттай, либерал боловсрол (liberal art education) олгодог цогцолбор (comprehensive) судалгааны их сургууль юм.

МУИС нь дэлхийн тэргүүлэх их сургуулиудын нэгэн адил өрсөлдөөнд суурилсан, нээлттэй байдал, оюутны сонголтыг дээдэлсэн либерал боловсролын дүнд шинжлэх ухааны гүнзгий мэдлэг, нийгмийн аливаа харилцааг ойлгож, хошуучлагч байж бүтээлчээр сэтгэн, шийдвэр гаргадаг, байнга хөгждөг, мэргэжлийн өндөр үр чадвартай хариуцлагатай иргэн бэлдэнэ.

МУИС-ийн оюутан үндсэн мэргэжлийн зэрэгцээ хос болон хавсарга мэргэжил, гадаад хэлний өндөр мэдлэг чадвар эзэмшин дэлхийн олон арван их сургуулиудын оюутан солилцоо, хамтарсан сургалт, багц цаг тооцох хөтөлбөрүүдэд хамрагдах боломжтой.

МУИС-ийн оюутан тэтгэлгээр суралцаж, үндэсний тэтгэлэг, тэргүүлэх чиглэлийн мэргэжлийн хөтөлбөрт үзүүлдэг засгийн газрын дэмжлэгт хамрагдах боломжтой бөгөөд МУИС-ийн нэрэмжит болон гадаад дотоодын байгууллага, иргэдийн олон арван тэтгэлэгт хөтөлбөрт эн тэргүүнд хамрагдах боломжтой.

МУИС-ийн оюутан соёл урлаг, спорт, нийгмийн идэвхтэй үйл ажиллагааны чиглэлээр өөрийгөө хөгжүүлэх, профессор, багшийн судалгааны төсөлд оролцож, эрдэм шинжилгээний хурал семинарт оролцох өргөн боломжоор хангагдана.

ХЭРХЭН ЭЛСЭХ ВЭ?

МОНГОЛ УЛСЫН ИХ СУРГУУЛЬД ЭЛССЭНЭЭР ТА



Суурь шалгалт нь 750-аас дээш оноотой ШУС-БУС, ХШУИС-ийн эхний 50 элсэгч /сургууль тус бүрт 25/ болон улсын олимпиадад эхний байр эзэлсэн элсэгчийн эхний хичээлийн жилийн сургалтын төлбөрийг 50 хувь хөнгөлнө.

ШУС, ХШУИС-д элссэн оюутан тухайн сургуулиудын бүх хөтөлбөрөөс сонгох боломжтой.

Хос болон хавсрага мэргэжилээр суралцах боломжтой.

ШУС, ХШУИС-ийн оюутан гүнзгийрүүлсэн сургалтат хөтөлбөрт /honors program/ хамрагдах боломжтой.

МУИС-ийн Ерөнхий сүүрийн зарим хичээлийг англи хэл дээр судлах боломжтой.

Шинжлэх ухааны сургууль					
Байгалийн ухааны салбар		Нийгмийн ухааны салбар		Хүмүүнлэгийн ухааны салбар	
Суурь шалгалт (60%)	Дагалдах шалгалт (40%)	Суурь шалгалт (60%)	Дагалдах шалгалт (40%)	Суурь шалгалт (60%)	Дагалдах шалгалт (40%)
- Биологи - Газарзүй - Математик - Физик - Хими	- Англи хэл - Биологи - Газарзүй - Монгол хэл - Математик - Монголын түүх - Нийгмийн тухай мэдлэг - Физик - Хими	- Монголын түүх - Математик - Нийгмийн тухай мэдлэг	- Англи хэл - Биологи - Газарзүй - Монгол хэл - Математик - Монголын түүх - Орос хэл - Физик - Хими	- Англи хэл - Монгол хэл - Монголын түүх - Нийгмийн тухай мэдлэг - Орос хэл	- Англи хэл - Биологи - Газарзүй - Математик - Монгол хэл - Монголын түүх - Нийгмийн тухай мэдлэг - Орос хэл - Физик - Хими

Хэрэглээний шинжлэх ухаан, инженерчлэлийн сургууль	
Суурь шалгалт (60%)	Дагалдах шалгалт (40%)
- Биологи - Математик - Физик - Хими	- Биологи - Газарзүй - Монгол хэл - Математик - Физик - Хими

Бизнесийн сургууль	
Суурь шалгалт (80%)	Дагалдах шалгалт (20%)
Математик	- Англи хэл - Нийгмийн тухай мэдлэг - Орос хэл

Хууль зүйн сургууль	
Суурь шалгалт (60%)	Дагалдах шалгалт (40%)
Нийгмийн тухай мэдлэг	Математик

Олон улсын харилцаа, нийтийн удирдлагын сургууль	
Суурь шалгалт (60%)	Дагалдах шалгалт (40%)
- Англи хэл - Математик - Монгол хэл - Монголын түүх - Нийгмийн тухай мэдлэг - Орос хэл	- Англи хэл - Математик - Монгол хэл - Монголын түүх - Нийгмийн тухай мэдлэг - Орос хэл

Завхан сургууль	
Суурь шалгалт (60%)	Дагалдах шалгалт (40%)
Нягтлан бодох, Санхүү банк, Менежмент, Маркетинг, Худалдаа, Бичиг хэрэг, оффисийн ажилтан	
Математик	- Англи хэл - Нийгмийн тухай мэдлэг
Электрон системийн автоматжуулалт	
- Математик - Физик	- Биологи - Математик - Физик - Хими
Багш, гадаад хэлний боловсрол (Англи)	
- Англи хэл - Орос хэл	- Англи хэл - Математик - Монгол хэл - Орос хэл

Орхон сургууль	
Суурь шалгалт (60%)	Дагалдах шалгалт (40%)
Багш, гадаад хэлний боловсрол, гадаад хэлний орчуулга	
- Англи хэл - Орос хэл	- Монгол хэл - Нийгмийн тухай мэдлэг - Англи хэл - Орос хэл
Багш монгол хэл, уран зохиолын боловсрол	
Монгол хэл	- Англи хэл - Монгол хэл - Нийгмийн тухай мэдлэг - Орос хэл
Нягтлан бодох, Санхүү банк, Даатгал, Менежмент, Маркетинг	
Математик	- Англи хэл - Нийгмийн тухай мэдлэг

ШИНЖЛЭХ УХААНЫ СҮРГУУЛЬ

Шинжлэх Ухааны Сургууль нь Байгаль, Нийгэм, Хүмүүнлэгийн ухаан гэсэн 3 салбартай бөгөөд оюутан суралцагчдад либерал арт буюу байгаль, нийгэм, хүмүүнлэгийн ухааны чиглэлээр мэргэжил эзэмшүүлэх шинжлэх ухааны суурь чиглэлүүдээр ахисан түвшний сургалт явуулдаг.

ШУС-ийн гол зорилгын нэг бол олон талын чадвартай, өөрийгөө байнга хөгжүүлэх эрмэлзлэлтэй, мэргэжилтэй чадварлаг боловсон хүчнийг бэлтгэх явдал юм.



ШИНЖЛЭХ УХААНЫ СҮРГУУЛИЙН БАЙГАЛИЙН УХААНЫ САЛБАР

- Багш, байгалийн ухааны боловсрол
- Багш, математикийн боловсрол
- Байгаль орчныг зайнаас тандан судлал
- Биологи
- Биологийн нөөц судлал
- Биохими
- Биотехнологи
- Газарзүй
- Газар зохион байгуулалт
- Геологи
- Геофизик
- Математик
- Физик
- Хими
- Хот ба бүс нутгийн төлөвлөлт
- Экологи

ШУС нь шинжлэх ухааны суурь чиглэлүүдээр сургалт, судалгааны ажил эрхлэн явуулдаг мэргэжлийн 19 тэнхим, 1 сургалтын төвд 470 гаруй багш, 90 орчим ажилтан, бакалаврын түвшний 9200 гаруй оюутан, ахисан түвшний 1900 гаруй суралцагчтайгаар үйл ажиллагаа явуулж байна. Тус сургуулийн багш судлаачдын 50 гаруй хувь нь АНУ, Англи, Франц, ХБНГУ, Япон, БНСУ зэрэг гадаадын өндөр хөгжилтэй улс орнуудад суралцаж магистр, докторын зэрэг хамгаалсан, багш нарын 60 гаруй хувь нь боловсролын болон шинжлэх ухааны докторын зэрэгтэй.



Дэлгэрэнгүй мэдээллийг <http://sas.num.edu.mn> сайтнаас авч болно.



ШУС-д сурснаар оюутан Та:

- Гүн гүнзгий мэдлэг, олон талын чадвар эзэмшиж, бүтээлчээр сэтгэх, асуудал шийдвэрлэх аргад суралцана.
- Шинжлэх ухааны олон чиглэлээр үр дүнтэй суралцах орчин нөхцлөөр хангагдана.
- Профессор багш, судлаачдын удирдан гүйцэтгэж буй судалгааны төсөл хөтөлбөрт оролцон ажиллах боломжоор хангагдана.
- Суралцах хөтөлбөрөө өөрөө сонгож бүрдүүлэх замаар бие даан суралцах орчин нөхцлөөр хангагдана.

ШИНЖЛЭХ УХААНЫ СУРГУУЛИЙН НИЙГМИЙН УХААНЫ САЛБАР

- Антропологи
- Археологи
- Нийгмийн ажил
- Социологи
- Сэтгүүлзүй
- Сэтгэл судлал
- Улс төр судлал
- Эдийн засаг

ШИНЖЛЭХ УХААНЫ СУРГУУЛИЙН ХҮМҮҮНЛЭГИЙН УХААНЫ САЛБАР

- Багш, гадаад хэлний боловсрол
- Багш, монгол хэл- уран зохиолын боловсрол
- Багш, нийгмийн ухааны боловсрол
- Гадаад хэлний орчуулга
- Олон улс, орон судлал
- Түүх
- Урлаг судлал
- Утга зохиол судлал
- Философи
- Хэл, уран зохиол /Монгол хэл, уран зохиол, Гадаад хэл, уран зохиол/
- Хэлшинжлэл /Монгол хэл шинжлэл, Гадаад хэл шинжлэл/
- Шашин судлал



ХЭРЭГЛЭЭНИЙ ШИНЖЛЭХ УХААН ИНЖЕНЕРЧЛЭЛИЙН СҮРГУУЛЬ

Хэрэглээний Шинжлэх Ухаан, Инженерчлэлийн Сургууль нь шинжлэх ухааны нээлт, инноваци, хуримтлагдсан мэдлэгийг техникийн ололт амжилттай хослуулан амьдрал, практикт хэрэглэх, байгалийн нөөц баялгийг зөв зохистой технологид тулгуурлан ашиглах, нөхөн сэргээх замаар өнөө үед тулгамдаад байгаа асуудлыг шийдвэрлэх гарцыг эрэн хайх арга замд элсэгч та бүхнийг суралцуулна.



Тус сургууль гадаад болон дотоодод эрдмийн зэрэг цол хамгаалсан 120 гаруй профессор, багш нартай. Хэрэглээний математик, Мэдээлэл, компьютерийн ухаан, Электроник, холбооны инженерчлэл болон Хүрээлэн буй орчин судлал, химийн инженерчлэл гэсэн мэргэжлийн 4 тэнхимтэйгээр сургалт, судалгааны ажлыг зохион байгуулж байна.

ХЭРЭГЛЭЭНИЙ ШИНЖЛЭХ УХААН, ИНЖЕНЕРЧЛЭЛИЙН СҮРГУУЛЬ

- Байгаль орчныг хамгаалах технологи
- Био-инженерчлэл
- Компьютерийн сүлжээ
- Компьютерийн ухаан
- Материал судлал
- Мэдээллийн систем
- Мэдээллийн технологи
- Нано шинжлэх ухаан, инженерчлэл
- Ойн үйлдвэрлэлийн техник, технологи
- Программ хангамж
- Статистик
- Сэргээгдэх эрчим хүч
- Ус судлал
- Химийн инженерчлэл
- Холбооны технологи
- Хүрээлэн буй орчин судлал
- Хэрэглээний математик
- Хэрэглээний хими
- Цаг уур
- Цөмийн инженерчлэл
- Электрон системийн автоматжуулалт





Бид энэ хичээлийн жилээс уламжлалт сургалтаа явуулахаас гадна, Стенфордын их сургуультай хамтарсан он-лайн сургалт явуулах бөгөөд ийм төрлийн сургалт явуулах орон зай, боловсон хүчин бүрдэж байгаа нь гурав дахь үеийн сургалтын эхлэл тус сургууль дээр тавигдаж байгаа юм.



Дэлгэрэнгүй мэдээллийг <http://seas.num.edu.mn> цахим хуудаснаас авна уу

МУИС-ийн Оюутан
Монголын ирээдүй

БИЗНЕСИЙН СУРГУУЛЬ

Бизнесийн Сургууль нь Бизнесийн удирдлагын чиглэлээр олон улсын хөгжлийн нийтлэг хандлагад нийцсэн эрдэм шинжилгээ, сургалтын үйл ажиллагаа явуулж, даяаршиж буй дэлхийд өрсөлдөх чадвартай мэргэжилтэн бэлтгэхэд оршино.



БИЗНЕСИЙН СУРГУУЛЬ

- Аялал жуулчлалын менежемент
- Бизнесийн удирдлага
- Даатгал
- Зочлох үйлчилгээ
- Маркетинг
- Менежмент
- Худалдаа
- Нягтлан бодох бүртгэл
- Санхүү, банк





Олон улсын ACBSP байгууллагаар магадлан итгэмжлэгдсэн Санхүү, банк, даатгал, нягтлан бодох бүртгэл, менежмент, маркетинг, худалдаа, аялал жуулчлал, зочлох үйлчилгээ зэрэг бизнесийн удирдлагын хөтөлбөрүүдээс сонгон суралцаж олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн дипломтой төгсөх боломжтой.



Нийт багш нарын 45% эрдмийн зэрэг цолтой, судалгаа, шинжилгээний болон заах арга зүйн өндөр ур чадварыг эзэмшсэн.

Гадаадын нэр хүндтэй хэд хэдэн их дээд сургуультай хамтран ажиллаж, хамтарсан хөтөлбөрүүд хэрэгжүүлдэг.



Дэлгэрэнгүй мэдээллийг <http://bs.num.edu.mn> сайтнаас авч болно.

МУИС-ийн Оюутан
Монголын ирээдүй

ХУУЛЬ ЗҮЙН СҮРГУУЛЬ

Хууль Зүйн Сургууль нь хууль зүйн эрдэм судлал, сургалтын талбарт үндэсний тэргүүлэх төв байж, нийгэмд манлайлах чадвартай, хууль, шударга ёсны төлөө үнэнч ажиллах, мэргэжлийн өндөр үр чадвартай, ёс зүйтэй эрх зүйчдийг бэлтгэхэд оршино.



Манай сургуулийн багш нарын 40 гаруй хувь нь гадаадын өндөр хөгжилтэй, тухайлбал, АНУ, Япон, БНСУ, ХБНГУ, ОХУ, Украин зэрэг улсад магистр, докторын зэрэг хамгаалсан. Багш нарын 50 гаруй хувь нь хууль зүйн ухааны болон шинжлэх ухааны докторын зэрэгтэй.



ХУУЛЬ ЗҮЙН СҮРГУУЛЬ

- Эрхзүй



Сургалтын хөтөлбөр нь Эрх зүйн мэргэжлийн дээд боловсролын Монгол Улсын стандартын дагуу хэрэгждэг ба орчин үеийн сургалттай, дэлхийн хөгжлийн түгээмэл хандлага, эдийн засаг-нийгмийн хэрэгцээ шаардлагад нийцсэн, хөрвөх чадвартай, эрх зүйн онолын өргөн мэдлэг, хуульчийн мэргэжлийн ёс зүй, хандлага, мэргэжлийн өндөр үр чадварыг эзэмшүүлдэг.



Дэлгэрэнгүй мэдээллийг <http://law.num.edu.mn> цахим хуудаснаас авна уу



ОЛОН УЛСЫН ХАРИЛЦАА НИЙТИЙН УДИРДЛАГЫН СУРГУУЛЬ

Олон Улсын Харилцаа, Нийтийн Удирдлагын Сургууль нь олон улсын харилцаа, нийтийн удирдлагын чиглэлээр сургалт, эрдэм шинжилгээ, судалгааны ажлаараа үндэсний цөм байж, дэлхийн жишигт нийцсэн үйл ажиллагаа явуулж, судалгаанд суурилсан мэдлэгтэй, улс эх орныхоо эрх ашгийг олон улсын хэмжээнд хамгаалах, иргэн төвтэй засаглалыг хэрэгжүүлэх, нийгэмд манлайлах чадвартай мэргэжилтэн бэлтгэдэг, салбартаа тэргүүлэх сургууль байхад оршино.

ОЛОН УЛСЫН ХАРИЛЦАА, НИЙТИЙН УДИРДЛАГЫН СУРГУУЛЬ

- Нийтийн удирдлага
- Олон улсын харилцаа



Олон улсын харилцаа хөтөлбөр нь Монгол улсын гадаад бодлогыг боловсруулах, хэрэгжүүлэх, олон улсын харилцааны нөхцөл байдалд дүн шинжилгээ, үнэлэлт дүгнэлт өгч чадахуйц мэдлэг чадвартай, олон улсын улс төр, эдийн засаг, эрх зүйн харилцааны чиглэлээр мэргэшсэн, гадаад хэлний өндөр

мэдлэгтэй, төрийн болон төрийн бус байгууллагуудын гадаад харилцааны салбарт ажиллах чадвар дадал эзэмшсэн олон улсын харилцааны мэргэжилтэн бэлтгэхэд хөтөлбөрийн гол агуулга чиглэгдэж байна.



Нийтийн удирдлагын хөтөлбөр нь Монгол Улсын нийгэм, эдийн засагт нийтийн удирдлага төр, төрийн бус байгууллага, төр ба хувийн хэвшлийн түншлэл, олон нийтийн байгууллагуудын гүйцэтгэх үүрэг ихээхэн өссөөр байгаа хэдий ч нийгэм, хууль эрх зүй, удирдахуйн ухаанд суурилсан чадварлаг мэргэжилтэн системтэйгээр бэлтгэх сургалтын тогтолцоог сайжруулах шаардлага тулгарч буй тул нийтийн удирдлагын чадварлаг мэргэжилтэн бэлтгэхэд хөтөлбөрийн агуулга чиглэгдэж байна.

Дэлгэрэнгүй мэдээллийг <http://sirpa.num.edu.mn> сайтнаас авч болно.

ОРХОН СУРГУУЛЬ

Орхон Сургууль нь нийгэм, хүмүүнлэгийн салбарт мэдлэг бүтээж түгээн дэлгэрүүлдэг, олон улсын жишигт нийцэхүйц эрдэм шинжилгээ, судалгааны тэргүүлэх төв байж, нийгэмд ашиг тусаа өгсөн сургууль байна.



ОРХОН СУРГУУЛЬ

- Багш, гадаад хэлний боловсрол
- Гадаад хэлний орчуулга
- Багш, монгол хэл-уран зохиолын боловсрол
- Даатгал
- Маркетинг
- Менежмент
- Нягтлан бодох бүртгэл
- Санхүү, банк



Дэлгэрэнгүй мэдээллийг <http://muis-orkhon.mn> цахим хуудаснаас авна уу

ЗАВХАН СҮРГУУЛЬ

Завхан Сургууль нь МУИС-ийн дээд боловсролын сургалтын үйл ажиллагааг баруун бүс нутагт явуулж, Монголын баруун бүсийн аймгуудыг “Бизнесийн удирдлага”-ын мэргэжилтэй боловсон хүчнээр хангахад шийдвэрлэх үүрэг гүйцэтгэдэг боловсролын 2 дахь шатны магадлан итгэмжлэлд орсон салбар сургууль юм.



Тус сургууль МУИС-ийн Бизнесийн сургуулийн сургалтын төлөвлөгөө, хичээлийн хөтөлбөрөөр сургалт явуулж байна.



ЗАВХАН СҮРГУУЛЬ

- Нягтлан бодох бүртгэл
- Санхүү, банк
- Маркетинг
- Менежмент
- Худалдаа
- Бичиг хэрэг, оффисийн ажилтан
- Электрон системийн автоматжуулалт
- Багш, гадаад хэлний боловсрол (англи)



Дэлгэрэнгүй мэдээллийг <http://za.num.edu.mn> сайтнаас авч болно.

МУИС-ийн Оюутан
Монголын ирээдүй

ТЭТГЭЛЭГ

ТЭТГЭЛЭГТ ХЭН ХАМРАГДАХ ВЭ ?

Тэтгэлэгийн зорилго:

Монгол улсын их сургуульд суралцаж буй оюунлаг, авьяаслаг, тэргүүний оюутнууд, түүнчлэн амжилттай суралцаж байгаа хэдий ч амьдралын боломж муутай суралцагчдад санхүүгийн дэмжлэг үзүүлэх, сурах үйлсийг дэмжих зорилготой гадаад дотоодын хувь хүн, байгууллагын 10 гаран тэтгэлэгт хамрагдах боломжтой.

ТЭТГЭЛЭГТ ТАВИГДАХ ШААРДЛАГА ЮУ ВЭ ?

Тэтгэлэгийн зорилго, хамрах хүрээнээс шалтгаалан тэтгэлэгт тавигдах шаардлага өөр өөр байх боловч нийтлэг хэд хэдэн шаардлага байна. Үүнд:

1. МУИС-д амжилттай суралцаж буй бакалавр, магистр, докторын түвшний өдрийн ангийн оюутан байх
2. Сурлагын үнэлгээний голч дүн /GPA/- 3.0 дээш голчтой байх
3. Оюутан нь давхар тэтгэлэгт хамрагдаагүй байх
4. Оюутан нь МУИС-ийн нэрийн өмнөөс олон улс, улс, бүс нутаг, их дээд сургуулиудын дунд зохиогдож байгаа эрдэм шинжилгээний хурал, олимпиад, спорт, урлагийн уралдаан тэмцээн, наадмуудад амжилттай оролцож эхний 3 байранд шалгарсан, мөн сайн дурын мэргэжлийн клубүүдийн үйл ажиллагаанд идэвхитэй оролцон, нийгэмд үнэлэгдэхүйц байдлыг үнэлэн тэтгэлэг олгоно.

БҮРТГЭЛ, ШАЛГАРУУЛАЛТЫГ ХЭРХЭН ЗОХИОН БАЙГУУЛДАГ ВЭ?


Тэтгэлэгийн зарыг МУИС-ийн

www.num.edu.mn, www.student.num.edu.mn

вебсайт дээр нээлттэй зарлах бөгөөд оюутнууд тухайн тэтгэлэгийн шаардлагад нийцэж байвал сонгон шалгаруулалтад оролцох нь мөн нээлттэй байдаг.

Оюутны алба нь Оюутанд санхүүгийн дэмжлэг үзүүлэх чиг үүргийн хүрээнд зарлагдсан тэтгэлэгийн шаардлагын дагуу суралцагчийн хүсэлт, холбогдох материалыг хүлээн авч, хянан баталгаажуулж холбогдох газарт хүргүүлнэ.

Тэтгэлэгийн сонгон шалгаруулалтыг тэтгэлэг зарлаж буй байгууллага, сан нь өөрсдийн шаардлагад нийцүүлэн жил бүр тодорхой тооны оюутанд шинээр буюу үргэлжлүүлэн тэтгэлэг олгох асуудлыг шийдвэрлэж, сонгон шалгаруулалтын эцсийн дүнг МУИС-д ирүүлнэ.



1. Хичээлийн I байр
2. Хичээлийн II байр
3. Хичээлийн III байр
4. Хичээлийн IV байр
5. Хичээлийн V байр
6. Хичээлийн VI байр
7. Хичээлийн VII байр
8. Хичээлийн VIII байр
9. Оюутны I байр
10. Оюутны II байр
11. Оюутны III байр
12. Оюутны IV байр
13. Оюутны V байр
14. Оюутны VI байр

№	Тэтгэлэгийн нэр	Тэтгэлэгийн болзол	Зарлагдах хугацаа
1	Монгол Улсын Ерөнхийлөгчийн нэрэмжит тэтгэлэг http://www.meds.gov.mn/PrsdntPM	Сурлага, урлаг, спортын онцгой амжилт үзүүлсэн тэргүүний суралцагч /ЗГ-ын 2008 оны 46 тогтоол, журмын дагуу/	6 сар
2	Монгол Улсын Ерөнхий сайдын нэрэмжит тэтгэлэг http://www.meds.gov.mn/PrsdntPM	Сурлага, урлаг, спортын онцгой амжилт үзүүлсэн тэргүүний суралцагч /ЗГ-ын 2008 оны 46 тогтоол, журмын дагуу/	6 сар

Дэлгэрэнгүй мэдээллийг <http://student.num.edu.mn> сайтнаас авч болно.



50%

Суурь шалгалт нь 750-аас дээш оноотой ШҮС-БУС, ХШУИС-ийн эхний 50 элсэгч /сургууль тус бүрт 25/ болон улсын олимпиадад эхний байр эзэлсэн элсэгчийн эхний хичээлийн жилийн сургалтын төлбөрийг 50 хувь хөнгөлнө.

3	МУИС-ийн нэрэмжит тэтгэлэг https://sisi.num.edu.mn/files/merged_document_3.pdf	- Олон улсын олимпиадад шагналт байр эзэлж медаль хүртсэн оюутан - Гурваас доошгүй улирал дараалан 3.2-оос доошгүй голч үнэлгээтэй суралцсан оюутан (байгалийн ухаан, инженерчлэлийн хөтөлбөрөөр суралцаж буй оюутны хувьд сурлагын голч дүн 3.0-аас доошгүй байх) - Суралцаж буй чиглэлээрээ их дээд сургуулиудын оюутны дунд зохион байгуулагддаг мэргэжлийн олимпиадад эхний 3 байр эзэлсэн оюутан - Улсын болон олон улсын чанартай урлаг, спортын наадам, уралдаан тэмцээнд МУИС-ийг төлөөлөн оролцож эхний 3 байр эзэлсэн оюутан	6 сар /хаврын семестрийн дүн гарсны дараа/
4	МУИС-ийн Эрдмийн Зөвлөлийн нэрэмжит тэтгэлэг https://sisi.num.edu.mn/files/merged_document_3.pdf	Улсын болон олон улсын чанартай оюутны эрдэм шинжилгээний хуралд амжилттай оролцож эхний 3 байрт шалгарсан суралцагч Судалгааныхаа ажлын үр дүнгээр шинэлэг үр дүн бүхий эрдэм шинжилгээний өгүүлэл бичиж олон улсын мэргэжлийн сэтгүүлд хэвлүүлсэн суралцагч Шинэ технологи, бүтээгдэхүүн, загвар боловсруулсан суралцагч	5 сар
5	Тайваний иргэн Өнө Уртагийн тэтгэлэг	Сурлагаар тэргүүний, амьжиргааны баталгаажих түвшнөөс доогуур орлоготой өрхийн суралцагч	6 сар /хаврын семестрийн дүн гарсны дараа/
6	Япон улсын “Сумитомо” корпорацийн нэрэмжит тэтгэлэг	Сурлагаар тэргүүний, амьжиргааны баталгаажих түвшнөөс доогуур орлоготой өрхийн суралцагч	3 сар /намрын семестрийн дүн гарсны дараа/
7	Япон улсын Мицубиши Корпорацийн нэрэмжит тэтгэлэг	Сурлага, нийгмийн идэвхи, оролцоо сайтай бакалавр, магистр, докторын түвшний суралцагч	10 сар
8	Японы Мицубиши UFJ сангийн нэрэмжит тэтгэлэг	Сурлагаар тэргүүлсэн, 2,3,4 дүгээр түвшний оюутан байна.	6 сар
9	БНСУ-ын “POSCO ASIA FELLOWSHIP”-ийн тэтгэлэг	Сурлагаар тэргүүний, амьжиргааны баталгаажих түвшнөөс доогуур орлоготой өрхийн суралцагч 2-3-р түвшний суралцагч байх	3 сар /хаврын семестрийн дүн гарсны дараа/
10	Тайваны Монгол-Төвдийн хорооны тэтгэлэг	Сурлага сайтай нийгмийн идэвхи, оролцоо сайтай магистр, доктор, бакалаврын түвшний суралцагч /хятад хэл суралцагчийг дэмжинэ/	3,11 сар

Дэлгэрэнгүй мэдээллийг <http://student.num.edu.mn> сайтнаас авч болно.

МУИС-ийн Оюутан
Монголын ирээдүй



11	Гаули ХХК-ийн нэрэмжит тэтгэлэг	Сурлага, нийгмийн идэвхи сайтай, өнчин, ар гэрийн гачигдалтай оюутнууд	9 сар
12	"Монгол-Намьянжу боловсролыг дэмжих сан"-ийн тэтгэлэг	Солонгос хэл судалж байгаа сурлага сайтай, амьжиргааны баталгаажих түвшнөөс доогуур орлоготой өрхийн суралцагч	9 сар
13	Голомт банкны нэрэмжит тэтгэлэг	Сурлага, нийгмийн идэвхи, оролцоо сайтай суралцагч /байгууллагын шалгуураар/	Олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр
14	Хас банкны тэтгэлэг	Сурлага, нийгмийн идэвхи, оролцоо сайтай суралцагч /байгууллагын шалгуураар/	Олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр
15	Азийн сангийн Ширын Панжу Мэрэли сангийн тэтгэлэг	Сурлага, нийгмийн идэвхи, оролцоо сайтай суралцагч /байгууллагын шалгуураар/	Олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр
16	Швецарийн хөгжлийн агентлагийн тэтгэлэг	Сурлага, нийгмийн идэвхи, оролцоо сайтай суралцагч /байгууллагын шалгуураар/	Олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр

- **Оюутан солилцооны хөтөлбөр** МУИС нь дэлхийн 170 гаруй орны их дээд сургуультай хамтын ажиллагааны гэрээтэй бөгөөд тэдгээртэй оюутан солилцооны хөтөлбөр хэрэгжүүлдэг. Тус сургуулийн оюутан нь БНСУ, Япон Улс, БНХАУ, Тайвань гэсэн Азийн улсуудаас гадна ОХУ, Итали, Испани, Франц, Герман зэрэг Европын их дээд сургуулиудад урт болон богино хугацаагаар тэтгэлэгт хөтөлбөрт хамрагдах боломжтой байдаг.
- **Эрүүл мэндийг дэмжих үйлчилгээ** МУИС-ийн эмнэлэг нь оюутнуудад нийгмийн эрүүл мэндийн болон эмнэлгийн анхан шатны тусламж, үйлчилгээг ерөнхий мэргэжлийн болон амны хөндийн эрүүл ахуйн чиглэлээр хүргэхээс гадна эрүүл мэндийн боловсрол олгох, зөвлөгөө өгөх чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг.
- **Хөдөлмөр эрхлэлт** Оюутнуудад хөдөлмөр эрхлэлт болон түүнтэй холбоотой асуудлаар зөвлөгөө өгөх, байнгын болон цагийн ажлын байрны талаарх мэдээллээр хангах, зуучлах, "Оюутныг хөдөлмөрийн зах зээлд бэлтгэх" сургалтын хөтөлбөр боловсруулж,

сургалт зохион байгуулах, төгсөгчдийн ажлын байрны судалгаа хийж ажлын байраар хангахад туслана.

- **Нийгмийн үйлчилгээ, сайн дурын арга хэмжээ** Нийтийн тээврээр үнэгүй зорчих, даатгал, нийгмийн халамжийн үйлчилгээнд хамрагдах, оюутны клуб, сайн дурын арга хэмжээнд хамрагдан хөгжих бололцоо олгоно.
- **Оюутны хөгжил, төлөвшил** Соёл, урлаг, спорт, аялал, чөлөөт цаг, олон нийтийн үйл ажиллагаа, урлагийн наадмууд, үзвэр үйлчилгээ, дугуйлан сургалт, лекц уулзалт, улсын болон олон улсын хэмжээний уралдаан тэмцээнд бэлтгэж оролцуулдаг.
- **Дотуур байр** МУИС нь оюутны зургаан байртай бөгөөд гадаадын 180, дотоодын 1200 оюутан хүлээн авах хүчин чадалтай.
- **Сургалтын болон бусад тусламж, зөвлөгөө** Сургалтын болон амьдрах, дасан зохицох чиглэлийн тусламж, зөвлөгөө өгөхөөс гадна Хууль эрхзүйн болон сэтгэлзүйн зөвлөгөө өгнө.

Дэлгэрэнгүй мэдээллийг <http://student.num.edu.mn> сайтнаас авч болно.